

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ  
эрдэм шинжилгээний бичиг

XXXVII (392)

2013

(23-27)

МОНГОЛ ХЭЛНИЙ УТГА, БҮТЭЦ СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Г. Буянтогтох \*

Өнөөгийн дэлхийн олон үндэстэн угсаатан бүр мянга мянган жилийг дамнасан оршихуйн түүхийн урт зам туулахдаа бие, хэл, сэтгэлийн хувьд тасралтгүй хөгжин боловсорч, тэр хэрээр орчлон ертөнцийг цаг ямагт танин мэдэж, ухаан билгийн дундрашгүй сан хөмрөг бүрдүүлж ирсэн нь өөрийн гэх өвөрмөц онцлог бүхий үндэстний сэтгэлгээ буюу сэтгэлгээний ертөнц бөгөөд сэтгэлгээний ертөнц гэдэг тухайн үндэстэн угсаатан нийтийн бүх мэдлэг туршлагын цөм, үндэстний оршихуйн утга учир, оршихуйн гүн ухаан, үндэстэн өөрөө юм. Товчдоо бол, үндэстний сэтгэлгээний ертөнц гэдэг хүн нэг бүрийн танин мэдэхүйгээр хуримталсан нийтийн оюуны болон практик үйлийн цогц үр дүн байдаг байна. Тодруулбал, танин мэдэх үйлийг ерийн танин мэдэхүй, шинжлэх ухааны танин мэдэхүй, философийн танин мэдэхүй гэх мэтээр ангилдгаас эхнийх нь хувь хүний өдөр тутмын ажил үйлийн мэдлэг туршлага дээр суурилсан мэдрэхүйн болон сэтгэхүйн төсөөлөл ойлголтоор илрэх мэдлэг бүтээх үйл байдаг байна. Түүнчлэн, ерийн танин мэдэх үйлийн явцад хүний хэл яриа, уялдаат сэтгэлгээ төлөвшдөг бөгөөд шинжлэх ухааны танин мэдэхүйн үндэс нь ерийн танин мэдэхүй болдог зүйтогтолтой байна (Лодой.2002.х - 4)<sup>1</sup>.

Тийм учраас үндэстний оршихуйн гүн ухаан буюу танин мэдэх сэтгэлгээний ертөнц энгийнээс нарийн руу, хөнгөнөөс хүнд рүү дараалан ахиж дэвшиж, хөгжиж гүнзгийрч ирсэн бөгөөд монгол сэтгэлгээний ертөнцийн утга, бүтцийг “ . . . тэнгэр мандал, сав шим ертөнц, тэдгээрийн хөдөлгөөн, хүний сэтгэхүйн хийсвэрлэл гэх зэргийн юм, үзэгдэл, харилцааны нэгж ухагдахуун тэмдэглэсэн цөм утгат нэрлэх дохионоос бүтэх бөгөөд тэрхүү цөм утгат нэрлэх дохиог тэнгэр мандлын эрхиээлт юмын нэр, шим ертөнцийн эрхиээлт юмын нэр, сав ертөнцийн эрхиээлт юмын нэр, тоо хэмжээний нэр, шинж чанарын нэр, орон цагийн нэр, асуух үг, заах үг гэсэн хэсгээс бүрдэнэ . . . тэнгэр мандлын холбоотой үгс гэвэл зөвхөн бүрээ, бишгүүр, овоо, хонх, манжлага, цамхаг гэсэн шүтлэг залбиралд хамаатай юмын нэрээр хязгаарлагдаж байгаа нь тухайн цагт тэнгэр мандлын эрхиээлт нэрийн зүйлсийн хэрэглээ өөрчлөгдөж багасч ирсэнтэй холбоотой”(Бадамдорж . 1997. х – 3 - 41)<sup>2</sup> гэх мэтээр ухааран ойлгож, дүгнэж тодорхойлж иржээ. Энэ нь сэтгэлгээний ертөнцийн ил хэсгийг гол болгоод, шууд бус буюу далд хэсгийг дутуу үнэлж, эсвэл, үгүйсгэж ирсэнтэй холбоотой нэлээд

\* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Хэл шинжлэлийн тэнхим

<sup>1</sup>) Г.Лодой.Философи ба шинжлэх ухааны аргазүй. УБ.2002

<sup>2</sup>) Д.Бадамдорж.Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс. УБ.1997

ерөнхий тойм шинжтэй ойлголт тодорхойлолт учраас цаашид монгол үндэстний сэтгэлгээний ертөнцийг далд, далд бус хоёр тал дээр, утга, бүтэц гэсэн үндсэн чиглэлээр нарийвчлан дэлгэрүүлэх боломжтой байна. Үүнд,

### **Монгол сэтгэлгээний ертөнцийн бүтэц**

1. Монгол сэтгэлгээний ертөнцийн авиан бүтэц. Нийлмэл ба нийлмэл бус авиан бүтэц. Эгшиг, гийгүүлэгч авианы утга. Г+Э, Э+Г+Э бүтэцтэй үе.

2. Монгол сэтгэлгээний ертөнцийн авиан бус бүтэц. Төгс утгат ба төгс бус утгат нэгж.  
- Монгол сэтгэлгээний ертөнцийн авиан бус, төгс утгат, бичил бүтэц буюу Өгүүлбэр, Цогцолбор. Бичил бус бүтэц буюу Мөчлөг, Эх.

- Монгол сэтгэлгээний ертөнцийн авиан бус, төгс бус утгат, үг бус бүтэц буюу Залгавар ба залгавар бус нэгж. Язгуур, дагавар, нөхцөл ба үгэлбэр.

- Монгол сэтгэлгээний ертөнцийн авиан бус, төгс бус утгат үг бүтэц буюу дан болон дан бус үг : Идэвхтэй ба идэвхгүй үг. Шинэ ба шинэхэн үг. Хуучин ба түүхэн үг. Эх хэлний ба харь хэлний үг. Төвийн болон захын аялгууны үг. Ном бичгийн ба ярианы үг. Уранзохиолын ба зохиогчийн үг. Хүндэтгэсэн ба үл хүндэтгэсэн үг. Эерэг ба сөрөг ерөөлийн үг. Этгээд ба этгээд бус үг. Цээр ба цээр бус үг. Оноосон нэр ба хоч нэр. Нийтийн ба мэргэжлийн үг. Нэр томъёо ба нууц үг. Тользүй

### **Монгол сэтгэлгээний ертөнцийн утга**

1. Далд ертөнцийн утга : Бурхан ба Бурхан бусын ертөнцийн утга.

- Зуурдын бус догшин ба догшин бус Бурханы далд ертөнцийн утга; зуурдын бус сайн заяаны ба сайн бус заяаны Бурхан бусын далд ертөнцийн утга. Тэнгэр, Асүрийн ба Бирд, Тамын ертөнцийн утга.

- Зуурдын далд ертөнцийн утга. Дүрстний ба дүрстэн бусын ертөнцийн утга.

2. Далд бус ертөнцийн утга : Сав ба Шим ертөнцийн утга.

- Өвс болон өвс бус ургамлын сав ертөнцийн утга.

- Ургамал бишийн сав ертөнцийн утга. Шороо, чулууны болон ус, чийгийн аймаг

- Хүний болон хүн бусын шим ертөнцийн утга.

Гэгээрсэн болон гэгээрч буй хүний ертөнцийн утга. Хутагт, Хувилгаан. Төгс болон төгс бус гүн ухаанаар гэгээрэхүйн ертөнцийн утга. Махчин болон махчин бус хүн бусын ертөнцийн утга

### **Монгол сэтгэлгээний ертөнцийн бүтцийн ангилал**

**1. Гарлаар нь:** Адуу, хуц, морь, мал, хутагт, хувилгаан гэх мэт Эх хэлний ба Бурхан, ням, даваа, мягмар, лхагва, баасан, бямба, эрдэнэ, автомат, килограмм, километр, цонх, пийшин, байцаа гэх мэи харь хэлний үг гэж ангилна.

**2. Хэрэглээний оронзайгаар нь :** Араат, үнэг, баавгай, баахалдай, хой, хонь гэх мэт Төвийн аялгууны болон захын аялгууны үг гэж ангилна.

**3. Хэрэглээний цаг хугацаагаар нь :** Хуучин ба хуучин бус үг

- Хуучин үгийг эртний ба түүхэн үг: Хэвтүүл, хишигтэн, хорин, и, а, нохун(нуган)

- Хуучин бус үгийг шинэ ба шинэ бус үг

- Шинэ үгийг шинэвтэр ба шинэхэн үг: Төв зах зээл, гар утас, даяаршил, багц цаг, Төрийн өмчийн сургууль, төрийн бус өмчийн сургууль

- Шинэ бус үгийг ойрхи(хам) цагийн ба ойрхи бус(цуваа) цагийн гэж ангилна: Их сургууль, цэцэрлэг, ахлах сургууль, мэргэжлийн сургалт, сургалтын төв, усан оргилуур гэх мэтээр ангилна.

**4. Хэрэглээний хүрээгээр нь :** Нийтийн (хоол, унд, хувцас хунар, ус, түлш) ба нийтийн бус үг

- Нийтийн бус үгийг мэргэжлийн ба мэргэжлийн бус үг

- Мэргэжлийн үгийг нэр томъёо ба тогтсон үг хэллэг:Хасагдагч, нэмэгдэхүүн, тосон боолт, аргаах эм, ороох, боох, цэгцэлгээ, зурам, найруулах, сэтгэлсудлал

- Мэргэжлийн бус үгийг нууц ба нууц бус үг гэж ангилна.

**5. Хэрэглээний зориулгаар нь :** Албан харилцааны ба албан бус харилцааны үг

- Албан харилцааны үгийг бичгийн ба бичгийн бус үг

- Албан бус харилцааны үгийг уранзохиолын ба уранзохиолын бус үг

- Уранзохиолын үгийг зохиогчийн ба зохиогчийн бус үг

- Уранзохиолын бус үгийг энгийн ярианы ба энгийн бус ярианы үг

- Энгийн ярианы үгийг ерийн ба ерийн бус үг

- Энгийн бус ярианы үгийг этгээд ба этгээд бус үг гэж ангилна.

**6. Хэрэглээний зэргээр нь :** Хүндэтгэсэн ба үл хүндэтгэсэн үг

- Хүндэтгэсэн үгийг ерийн ба ерийн бус үг:

- Ерийн үгийг цээр ба цээр бус үг :Чоно, мөлхөө, алах, төхөөрөх, үхэх, тэнгэрт халих, Та, ах, абугай, шившүүр, нигур, тэргүүн

- Ерийн бус үгийг ерөөлийн ба ерөөлийн бус үг: Зуун насал, алтаар урс,Төрийн сүлд ! Бурхан өршөө! Хайрхан! Буян тань дэлгэр

- Үл хүндэтгэсэн үгийг доромж ба доромж бус үг : (Чи, яв, ид, орох, Новш! Тэнэг! Еэ өгөр ! Гахай ! ) гэж ангилна.

**7. Хэрэглээний чанараар нь:** Идэвхтэй ба идэвхгүй үг

**8. Ухагдахуун тэмдэглэсэн байдлаар нь :**Хэлц ба хэлц бус үг

- Хэлцийг адилтгасан(сүүн сэтгэл, чонон санаа), эс адилтгасан(гар гаар, хөл хөсөр, гар ганзаганд, хөл дөрөөнд) хэлц үг:

- Хэлц бусыг төлөөлсөн, эс төлөөлсөн үг(хүн, мал, мод, чулуу)
- Төлөөлснийг хүнийг ба хүн бусыг төлөөлсөн үг гэж ангилна.

**9. Бүрэлдэхүүнээр нь:** Дан ба дан бус үг

- Дан үгийг ганц үет ба ганц бус үет
- Дан бус үгийг хоршсон(хоол унд, бичиг цаас, ус унд), эс хоршсон (төмөр зам, бал чулуу, зөгийн бал, цөцгийн тос) дан бус үг гэж ангилна.

**Монгол сэтгэлгээний ертөнцийн утгын ангилал**

**1. Утгын орон:** Гадаад ба дотоод орон

- Утгын гадаад орныг далд (**Бурхан ба Бурхан бусын ертөнц**) ба далд бус (**Сав ба Шим ертөнц**) ертөнцийн утгын орон
- Утгын дотоод орныг дээд (**догшин ба догшин бус Бурханы; Ургамал ба ургамал бусын**), дэд (**Улаан сахиусны ба Манзушрийн;Хиаг ба члүү**) утгын орон гэж ангилна.

**2. Утгын төрөл:** Цөм ба цөм бус утга

- Цөм утгыг гадаад(Хүн: Шим ертөнцийн дээд амьтан) ба дотоод шинж чанарын (**ертөнцийг танин мэдэж, төгс гэгээрэх чадал бүхий ухаан билиг төгөлдөр амьтан**), бүтцийн (**хү – 1. Хүлүг>үлүг>үлүү>илүү > 2. Хүй,үй;мү – буй, байгаа; н – амьтан буюу юм = одоо байгаа, маш хүчирхэг, онцгойрон шалгарсан нийгмийн амьтан**) утга
- Цөм бус утгыг зэрэгцүүлсэн(**сайн, монгол, малчин, хархүн, хүн мод, хүн гөрөөс, хүн эм, хүн хонхор, хүн од, хүн чулуу, хүн төрөлхтөн, хүн ам, хүн бүл**) ба эс зэрэгцүүлсэн(**хүн болох, мөстэй хүн, хүний хүн, шинэ хүн, хуучин хүн, хөндлөн хүн, хүн хөөдөх, зөөлөн хүн, хатуу хүн, нохой хүн, нүүргүй хүн, гаднын хүн, дотор хүн**) гэж ангилна.

**НОМ ЗҮЙ**

- Ю.Д.Апресян “Лексическая семантика”. Москва. 1995  
 Д.Бадамдорж.Орчин цагийн монгол хэлний утга судлалын үндэс.УБ.1997  
 Д.Бадамдорж “Монгол хэлний утгасудлал”.Тэргүүн дэвтэр.УБ.2001  
 Д.Бадамдорж “Монгол хэлний утгасудлал”.Дэд дэвтэр. УБ.2001  
 Д.Бадамдорж “Монгол хэлний утгасудлал”.Гутгаар дэвтэр. УБ.2001  
 М.Базаррагчаа.Монгол хэлний авиа сэлгэх ёс.УБ.1987  
 Ж.Баянсан. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ. УБ.2002  
 Ж.Баянсан, Ш.Одонтог. Хэлшинжлэлийн нэр томъёоны зүйлчилсэн тайлбар толь. УБ.1995  
 Л.М.Васильев “Современная лингвистическая семантика”. Москва. 1990  
 Дэлгэрмаа “Монгол хэлний утга судлал”. Бээжин. 2001  
 John Saeed “Semantics”. Oxford. 1997  
 Leech Geoffrey “Semantics”. England. 1974

- Г.Лодой.Философи ба шинжлэх ухааны аргазүй. УБ.2002  
Ш.Лувсанвандан “Хэлний өнгөн бүтэц, гүн бүтцийн тухай асуудалд” SM, UB.1978.  
10.Б.Ринчен “Үгийн утга учир”. Хөх хот. 1953.  
11.Ж.Төмөрцэрэн “Монгол хэлний үгийн сангийн судлал”. УБ.2001  
12.Цэцэн, Дэлгэрмаа “Утгазүй”. Бээжин. 1996

### **ABSTRACT**

Given article is devoted for the analysis semantic and lexical structure of mentality of Mongols, as expression external and a private world of knowledge. It is known, that progress of lexical semantics occurs owing to influence of two forces – constantly extending knowledge of the world and laws of knowledge of the world, that is consists in reflection of cumulative and gnosiological functions of language and grows out dynamical processes of mastering and transformation of knowledge.